



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

### Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 275 дугаар тогтоол, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 330 дугаар тогтоол, Газрын дүрмийн 7.1.1, 7.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс зөвшөөрөл олгосны дагуу Захиргаа, санхүүгийн хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Хотын хөгжлийн стандартын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Худалдаа, үйлчилгээний стандартын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Байгаль орчны стандартын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Стандарт хэрэгжилт, хяналтын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хууль, эрх зүй хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, Хотын хөгжлийн стандартын хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр, Худалдаа үйлчилгээний стандартын хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 10 дугаар, Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 11 дүгээр, Байгаль орчны стандартын хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтын 12 дугаар, Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтсийн Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 13 дугаар, Стандартын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 14 дүгээр, Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хяналт, шинжилгээ, үнэлгээний мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 15 дугаар, Гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 16 дугаар, Дотоод ажил, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 17 дугаар, Хотын хөгжлийн стандартын хэлтсийн Хот байгуулалтын стандарт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 18 дугаар, Хотын нийгмийн дэд бүтцийн стандарт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 19 дүгээр, Тогтвортой хотын стандарт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 20 дугаар, Хотын аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагын стандарт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 21 дүгээр, Хотын тээвэр, логистикийн стандарт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 22 дугаар, Худалдаа, үйлчилгээний стандартын хэлтсийн Худалдаа, үйлчилгээний байгууллагын стандарт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 23

1150500138

дугаар, Нийгмийн үйлчилгээний стандарт хариуцсан мэргэжилтний албан тушаалын 24 дүгээр, Бүртгэл, мэдээллийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 25 дугаар, Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтсийн Гудамж, зам, талбайн стандарт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 26 дугаар, Ногоон байгууламжийн стандарт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 27 дугаар, Инженер хангамжийн стандарт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 28 дугаар, Хог хаягдлын менежментийн стандарт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 29 дүгээр, Байгаль орчны стандартын хэлтсийн Хөрс, усны чанарын стандарт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 30 дугаар, Агаарын чанарын стандарт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 31 дүгээр, Бүртгэл, мэдээллийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 32 дугаар, Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтсийн Хот байгуулалтын стандарт хэрэгжүүлэлтийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтын 33 дугаар, Дэд бүтцийн стандарт хэрэгжүүлэлтийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 34 дүгээр, Хот тохижилтын стандарт хэрэгжүүлэлтийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 35 дугаар, Бүртгэл, мэдээллийн сангийн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 36 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан албан тушаалын тодорхойлолтын дагуу албан хаагчдыг үүрэгжүүлж, удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллахыг Хэлтсийн дарга нарт, төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөн бүрдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т, үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-д даалгасугай.

ДАРГА  С.ТӨМӨРДУПАМ